

Үндэсний илжрэлээр буудай болон бусад төрлийн үет таримал өвчилдөг. Үндэсний илжрэл өвчинг үүсгэгч олон төрлийн мөөг бий. Өвчнийг голдуу тухайн мөөгний төрлийн нэрээр нэрлэдэг. Эдгээрээс манай оронд гельминтоспориоз, фузариозын төрлийн мөөг түгээмэл тохиолддог.

Гельминтоспориозын үндэсний илжрэл

Өвчин үүсгэгч: *Bipolaris sorokiniana* (*Helminthosporium sativum*)

Өвчний шинж тэмдэг:

✚ Өвчилсэн үрийн соёо тахийж хүрэгтэн, хэлбэр нь алдагдаж, хөрсөн дээр цухуйж гарахаасаа өмнө үхнэ.

✚ Цухуйлтын үед анхны навчны углуурга, хожим ишний угт хүрэн өнгийн толбо, зураас үүснэ.

✚ Бутлалтын үед навчны уг хүрэгтэж, таримлын өсөлт хөгжилт удааширна.

✚ Гол хатгалт болон цэцэглэлтийн шатанд бутлалтын зангилаа, газрын дээрх болон доорх эхний зайдам, навчны уг хүрэгтэнэ.

✚ Цэцэглэлт болон сүүн болцын шатанд таримлын үндэс бага гэмтэх бөгөөд ишний уг, доод зайдмууд хүрэгтэнэ.

✚ Навчин дээр илтэсний дагуу сунасан хэлбэртэй, хар, хар сааралдуу, бор сааралдуу өнгийн толбо тогтоно. Толбон дээр мөөгөнцрийн спороос бүрдсэн бор, шар ногоон эсвэл хар саарал өнгийн өнгөр тогтоно. Өвчний энэ хэлбэрийг “**навчны хүрэн толбожилт**” гэж нэрлэдэг.

✚ Өвчний халдвар үрэнд нэвтэрч өвчлүүлсэний улмаас хөврөл харлана. Өвчний энэ хэлбэрийг “**үр хөврөл харлах**” гэж нэрлэнэ.

Өвчний хор хөнөөл:

-Өвчилсэн навч хатаж унана.

-Өвчилсэн ургамалд түрүү үүсдэггүй, ихэнх тохиолдолд ургамал үхнэ.



Өвчилсэн үндэс

Навчны хүрэн толбожилт



Өвчилсэн түрүү

Үрийн хөврөл харлах

Фузариозын үндэсний илжрэл

Уг өвчин *Fusarium* –ийн төрлийн мөөгөөр үүсгэгдэнэ.

Өвчний шинж тэмдэг:

- ✚ Анхдагч болон хоёрдогч үндэс, ишний уг хүрэлтэнэ
- ✚ Соёо хөрсөн дээр гарахаас өмнө илжирч гэмтэн үхнэ
- ✚ Ишний уг харлана, цэцэглэлтийн эхэн үед навч шарлаж унана
- ✚ Түрүү цайна, соёолох чадваргүй цагаан үр үүснэ
- ✚ Гэмтсэн ургамлын түрүүний хөгжил муу, үр хорчгор болно
- ✚ Чийгтэй үед өвчилсөн эрхтэн дээр цайвар, цайвар ягаан, улбаан ягаан (мөөгний зүйлээс шалтгаална) өнгөтэй өнгөр тогтоно.



Өвчилсөн түрүү, иш болон үр

Хор хөнөөл:

Энэ төрлийн мөөг нь хорт бодис ялгаруулдаг учраас өвчилсөн үр тариа, түүгээр хийсэн бүтээгдэхүүн хүн, амьтанд хордлого үүсгэх эрсдэл бий.

Өвчний эх үүсвэр: Үр, хөрсөнд хадгалагдана.

Үндэсний илжрэл өвчинтэй тэмцэх аргын менежмент:

Тарих үрийг лабораторийн шинжилгээнд хамруулж, өвчлөлтийг тодорхойлуулах, хэрэв халдварлалт 5% түүнээс дээш хэмжээтэй байвал тариалалтанд ашиглахгүй байвал зохино.

Агротехникийн арга:

- Үрийг ангилан ялгаж, сайн чанарын үрээр тариалалт хийх;
- Хөрсийг эрүүлжүүлэхийн тулд ээлжлэн тариалах системийг мөрдөх (сэлгээнд буурцагт ургамал, хошуу будаа, рапс, наранцэцэг г.м таримлыг тариалах);
- Хог ургамал ялангуяа үет хог ургамлыг устгах нь өвчний тархалтыг хязгаарлах сайн талтай.
- Талбай дахь өвчний голомтыг багасгахын тулд ургамлын үлдэгдэл болон гуурсыг хөрсөнд гүн булах;
- Үрийг хэтэрхий гүнд суулгах нь цухуйц өвчлөх эрсдлийг нэмэгдүүлдэг учраас тохирсон гүнд тарих;
- Таримлын өвчин тэсвэрлэлтийг сайжруулахын тулд кали, фосфорын бордоог зохих тунгаар хэрэглэх;
- Фузариозын голомттой талбайд шууд хураалт хийх

Химийн арга:

- Үрийг тарихаас өмнө Тебу 60, МЭ /0.3-0.4л/т/, Бункер ВСК /0.3-0.4л/т/, Виал Траст ВСК /0.3-0.5л/т/ Скарлет, МЭ /0.3-0.4л/т/ г.м зөвшөөрөгдсөн бодисоор ариутгах;

Ашигласан хэвлэл

Итгэл Ц, Бямбажав Б “Фитопатологийн дадлагын сурах бичиг” УБ, 1997
Дэжидмаа Т “Үр тарианы ургамлын өвчин” УБ, 2009
Пересыпкин В.Ф “Сельскохозяйственная фитопатология” Москва, 1989
George N. Agrios “Plant pathology” Fourth edition, 1997

МТҮХолбооны ажлын албанаас эмхэтгэн бэлтгэв.
2021 он.

404 room, Unity Center, Оюутны гудамж 44,
8-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот 14191, Монгол Улс
office@nationalfarmers.mn Умаc:7511-7500